



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 4/55

Баян-Өндөр сум

Албан тушаалын тодорхойлолтын төслийг  
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын ерөнхий хуулийг хэрэгжүүлэх зорилгоор цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн хэсгийн ахлагч:

Ч.Биндэръяа (Боловсрол, шинжлэх ухааны салбарын улсын хяналтын ахлах байцаагч)

Гишүүд:

Д.Дашням (Статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д.Энхцэцэг (Шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт, багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэн)

Д.Эрдэнэчимэг (Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Ц.Одгэрэл (Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал)

Ц.Чимэддулам (Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн захирал)

А.Төгсжаргал (Урлагийн төрөлжсөн сургалттай “Уран-Эгшиг” сургуулийн захирал)

Х.Энхсайхан (7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Н.Янжинлхам (17 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Г.Батцэцэг (27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэжаргал (Боловсролын салбарын эрх бүхий албан тушаалтан)

2.

2.Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал бүрээр шинэчлэн боловсруулахдаа Боловсролын ерөнхий хуульд заасан захирал, эрхлэгчид тавигдах тусгай шаардлагыг баримтлах, албан тушаалд тавигдах мэргэжил ба мэргэшлийн шаардлагыг тухайн албан тушаалын чиг үүрэгт нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтод тусгах, албан тушаалын онцлогоос хамаарч гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадварыг тухайн албан тушаалын чиг үүрэгтэй уялдуулан нэмэлтээр тогтоож ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Албан тушаалын тодорхойлолтын төслийг хуульд бүрэн нийцүүлэн чанартай боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Биндэрьяа)-д даалгасугай.

ДАРГА  О.АРИУНГЭРЭЛТ

